



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 4413

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн дөрөвдүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-т даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
04 дүгээр сарын 04-ны өдрийн
04/113 дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв	54/2025	3 жил	2025.03.13	2028.03.13
2.	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн Сэлбэ эмнэлэг	55/2025	2 жил	2025.03.12	2027.03.12
3.	Улаанбаатар хот, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	56/2025	3 жил	2025.03.12	2028.03.12
4.	Улаанбаатар хот, Энх-Ундарга ЗГБХН-ийн эмнэлэг	57/2025	3 жил	2025.03.19	2028.03.19
5.	Улаанбаатар хот, Хурилдуур ХХК-ийн эмнэлэг	58/2025	2 жил	2025.03.23	2027.03.23
6.	Дархан-Уул аймаг, Орхон сумын эрүүл мэндийн төв	59/2025	2 жил	2025.03.13	2027.03.13
7.	Дархан-Уул аймаг, Шарын гол сумын эрүүл мэндийн төв	60/2025	2 жил	2025.03.13	2027.03.13
8.	Дархан-Уул аймаг, Дархан өлзий од ХХК-ний Дархан-Үйлс эмнэлэг	61/2025	2 жил	2025.03.13	2027.03.13
9.	Дархан-Уул аймаг, Саран-энх ХХК-ний Саран энх эмнэлэг	62/2025	2 жил	2025.03.13	2027.03.13
10.	Төв аймаг, Батсүмбэр сумын эрүүл мэндийн төв	63/2025	2 жил	2025.04.18	2027.04.18
11.	Төв аймаг, Баянцогт сумын эрүүл мэндийн төв	64/2025	2 жил	2025.04.18	2027.04.18
12.	Төв аймаг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв	65/2025	3 жил	2025.04.18	2028.04.18
13.	Төв аймаг, Сүмбэр сумын эрүүл мэндийн төв	66/2025	2 жил	2025.04.18	2027.04.18
14.	Төв аймаг, Сэргэлэн сумын эрүүл мэндийн төв	67/2025	2 жил	2025.04.18	2027.04.18